



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/008/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2024он

Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас:261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: П.Чанцалдулам  
Утас:261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn  
Ахлах аудитор: Ж.Нямцэцэг  
Утас: 261740 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn  
Өлзийт экаунт аудит ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал: Ч.Эрдэнэжав  
Утас:88117655 Цахим хаяг: auditulziit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 07/1188  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН  
ХАДГАЛАМЖИЙН  
ТӨВ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
М.ЭНХСАЙХАН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцааны 2022, 2023, 2024 онуудын зарласан ногдол ашгаас 108,143.2 сая төгрөг тараагдаагүй үлдсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээний орлого 794.8 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 1,221.9 сая төгрөгөөр тус бүр давж биелсэн нь эдийн засгийн зорилтот түвшинг 1,264.3 сая төгрөгөөр давуулан биелүүлэхэд материаллаг нөлөө үзүүлсэн байна.

## Бусад асуудлын хэсэг

Компани нь тайлант онд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид 939 төрлийн 126,088.6 сая ширхэг үнэт цаасыг хадгалж, биржийн бус зах зээлд арилжаалах 361 төрлийн 1,885.2 сая төгрөгийн өрийн хэрэгсэл бүртгэн үйл ажиллагаа явуулсан байна. Эдгээр хадгалж байгаа үнэт цаас, өрийн хэрэгсэл нь тайлан тэнцлийн гадуур бүртгэгдэж байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2024 оны 01-р сарын 01	2024 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	68,711,770,831.04	165,784,260,948.60
1.1.2	Дансны авлага	203,293,371.35	181,702,622.75
1.1.4	Бусад авлага	1,197,853,034.88	1,098,432,254.79
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	24,471,178,782.60	23,224,134,927.88
1.1.6	Бараа материал	15,344,862.00	19,854,465.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	37,203,567.65	342,194,299.91
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>94,636,644,449.52</b>	<b>190,650,579,518.93</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,494,411,313.62	1,739,661,830.05
1.2.2	Биет бус хөрөнгө	101,006,339.92	118,333,981.45
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,595,417,653.54</b>	<b>1,857,995,811.50</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>96,232,062,103.06</b>	<b>192,508,575,330.43</b>
2.1.1.1	Дансны өглөг	12,149,187.05	29,047,306.00
2.1.1.2	Ажилтан албан хаагчдад өгөх өглөг	225,521.82	397,996.43
2.1.1.3	Татварын өр	39,163.96	19,317,149.47
2.1.1.4	НДШ-ийн өглөг	2,445,147.55	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	40,158,007.87	46,549,441.31
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	80,456,653,072.67	174,658,719,793.41
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>80,511,670,100.92</b>	<b>174,754,031,686.62</b>
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	526,723,301.65	714,385,161.20
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>526,723,301.65</b>	<b>714,385,161.20</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>81,038,393,402.57</b>	<b>175,468,416,847.82</b>
2.3.1	Өмч:-төрийн	5,000,000,000.00	5,000,000,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	159,548,938.00	159,548,938.00
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	10,034,119,762.49	11,880,609,544.61
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>15,193,668,700.49</b>	<b>17,040,158,482.61</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>96,232,062,103.06</b>	<b>192,508,575,330.43</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2024 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,781,994,546.05	3,606,603,432.90
2	Борлуулалтын өртөг	779,120,273.33	827,466,197.90
3	Нийт ашиг( алдагдал)	3,092,874,272.72	2,779,137,235.00
4	Хүүний орлого	2,755,953,837.93	3,921,933,126.65
5	Бусад орлого / Урсгал үйл ажиллагааны санхүүжилт ,орон нутгийн төсөвт байгууллага/	29,418,146.01	0.00
6	Ерөнхий ба удирдлагын зардал	1,578,397,899.39	1,870,197,896.10
7	Бусад зардал	34,434,430.00	418,106,475.00
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(164,292.38)	(21,305.50)
9	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	4,265,249,634.89	4,412,744,685.05
10	Орлогын татварын зардал	512,012,443.95	501,974,443.38
11	Татварын дараах ашиг (алдагдал)	3,753,237,190.94	3,910,770,241.67
12	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	3,753,237,190.94	3,910,770,241.67

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>5,000,000,000.00</b>	<b>159,548,938.00</b>	<b>7,235,947,673.20</b>	<b>12,395,496,611.20</b>
Залруулсан үлдэгдэл	5,000,000,000.00	159,548,938.00	7,235,947,673.20	12,395,496,611.20
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	3,753,237,190.94	3,753,237,190.94
Зарласан ногдол ашиг	-	-	955,65,101.65	955,65,101.65
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>5,000,000,000.00</b>	<b>159,548,938.00</b>	<b>10,034,119,762.59</b>	<b>15,193,668,700.49</b>
Залруулсан үлдэгдэл	5,000,000,000.00	159,548,938.00	10,034,119,762.59	15,193,668,700.49
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	3,910,770,241.67	15,193,668,700.49
Зарласан ногдол ашиг	-	-	2,064,280,459.55	2,064,280,459.55
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>5,000,000,000.00</b>	<b>159,548,938.00</b>	<b>11,880,609,544.61</b>	<b>17,040,158,482.61</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,288,764,429,2399.95	18,497,820,736,815.10
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,667,978,527.85	3,606,603,432.90
1.1.6	Бусад мөнгөн орлого	4,285,096,450,712.10	18,494,214,133,382.20
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>4,312,669,789,714.49</b>	<b>18,402,462,598,475.00</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,113,284,752.57	1,620,550,454.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	309,313,710.10	367,352,353.92
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	24,252,874.00	28,973,023.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	58,539,242.53	30,382,754.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,311,397.00	2,332,300.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	790,189,918.22	647,481,890.29
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	3,742,010.00	2,973,213.20
1.2.9	Бусад мөнгөн зарлага	4,312,657,187,158.94	18,403,684,485,613.20
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(23,905,360,474.54)</b>	<b>95,358,138,340.09</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	20,943,759,260.92	646,271,137.46
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(18,654,727,912.05)</b>	<b>2,629,390,851.73</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(43,428,493,678.97)</b>	<b>97,072,490,117.56</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	Тайлант оны		Зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1.Нийт орлого</b>	<b>7,528,515,000.00</b>	<b>6,264,176,000.00</b>	<b>7,528,515,000.00</b>	<b>(42,406,000.00)</b>	<b>101.0</b>
Үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээний орлого	2,019,373,000.00	1,224,591,000.00	2,019,373,000.00	(794,782,000.00)	165.0
Үнэт цаасны өмчлөх эрх бүртгэлийн орлого	1,303,813,000.00	1,562,253,000.00	1,303,813,000.00	258,440,000.00	83.0
Кастодианы үйлчилгээний орлого	26,946,000.00	16,596,000.00	26,946,000.00	(10,350,000.00)	162.0
Төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааны орлого	197,183,000.00	692,736,000.00	197,183,000.00	495,533,000.00	28.0
Бусад орлогын дүн	59,267,000.00	68,000.00	59,267,000.00	8,733,000.00	87.0
Үйл ажиллагааны бус орлого	3,921,933,000.00	2,700,000,000.00	3,921,933,000.00	(1,221,933,000.00)	145.0
<b>2.Нийт зардал</b>	<b>3,115,770,570.00</b>	<b>3,564,569,850.00</b>	<b>3,115,770,570.00</b>	<b>448,799,280.00</b>	<b>87.4</b>
Үндсэн цалин	1,288,087,080.00	1,507,510,000.00	1,288,087,080.00	219,422,920.00	85.0
Хөнгөлөлтийн зардал	123,330,000.00	148,200,000.00	123,330,000.00	24,870,000.00	83.0
Нийгмийн даатгалд төлөх шимтгэл	189,727,720.00	206,963,750.00	189,727,720.00	17,236,030.00	92.0
Шатахуун	2,332,300.00	2,500,000.00	2,332,300.00	167,700.00	93.0
Үндсэн хөрөнгийн элэгдэл	383,692,980.00	330,000,000.00	383,692,980.00	(53,692,980.00)	116.0
Бичиг хэрэгсэл	11,399,180.00	15,000,000.00	11,399,180.00	3,600,820.00	76.0
Хангамжийн материал	12,539,400.00	17,411,700.00	12,539,400.00	4,872,300.00	72.0
Ариун цэврийн зардал	600,000.00	600,000.00	600,000.00	0.00	100.0
Засвар үйлчилгээ	6,441,060.00	19,785,000.00	6,441,060.00	13,343,940.00	33.0
Цахилгаан	16,803,550.00	21,196,800.00	16,803,550.00	4,393,250.00	79.0
Цэвэр бохир ус	1,904,870.00	2,300,000.00	1,904,870.00	395,130.00	83.0
Халаалт дулаан	3,274,330.00	4,121,600.00	3,274,330.00	847,270.00	79.0
Харилцаа холбоо	25,430,970.00	24,036,000.00	25,430,970.00	(1,394,970.00)	106.0
Үндсэн хөрөнгийн татвар	15,300,000.00	15,300,000.00	15,300,000.00	0.00	100.0
Газрын төлбөр	15,613,640.00	16,700,000.00	15,613,640.00	1,086,360.00	93.0
Тээврийн хэрэгслийн татвар	99,280.00	150,000.00	99,280.00	50,720.00	66.0
Даатгалын үйлчилгээ	2,973,210.00	3,750,000.00	2,973,210.00	776,790.00	79.0
Албан томилолт	149,235,320.00	171,202,000.00	149,235,320.00	21,966,680.00	87.0
Сургалт сурталчилгаа	17,724,600.00	21,230,000.00	17,724,600.00	3,505,400.00	83.0
Тэтгэвэр тэтгэмж, шагнал	11,513,500.00	77,100,000.00	11,513,500.00	65,586,500.00	15.0
Үйл ажиллагааны бусад	419,641,100.00	529,513,000.00	419,641,100.00	109,871,900.00	87.0
<b>3.Ашиг алдагдал</b>	<b>4,412,744,430.00</b>	<b>2,699,606,150.00</b>	<b>4,412,744,430.00</b>	<b>1,713,138,280.00</b>	<b>163.0</b>

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 35.9 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 9.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 26.9 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Тэмцээн уралдаан зохион байгуулахад 5.4 сая төгрөгийн зардал гаргасан байна.	1	5,410.0			1	5,410.0						
Бэлэн мөнгөний 0.5 сая төгрөгийн орлого, зарлагын баримтыг иж бүрэн хөтөлж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй.	1	482.5					1	482.5				
НБББББ болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд заасан элэгдэл тооцох хугацааг зөрүүтэй тооцсоноор 26.5 сая төгрөгөөр элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан.	1	26,502.6					1	26,502.6				
Бичиг хэргийн материалын үлдэгдэлд 2016 оны 277 ширхэг 3.5 сая төгрөгийн ажлын тайлан, хууль тогтоомжийн эмхэтгэл бүртгэлтэй байна.	1	3,556.5			1	3,556.5						
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>35,951.6</b>			<b>2</b>	<b>8,966.5</b>	<b>2</b>	<b>26,895.1</b>				

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**3.2** АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар илэрсэн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант хугацааны худалдан авалтыг зохион байгуулахдаа үнэлгээний хороог томилоогүй, үнэлгээний хороогоор тендерийн бичиг баримтыг хэлэлцүүлээгүй, үнэлгээний хянан үзэх үе шатны ажлыг иж бүрэн хийж үнэлээгүй байна.	1	-			1	-		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>		